



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2024/02/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2024 оны 02 дүгээр сарын 19</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитор: Н.Бунчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsuren@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

ଆକାଶ, ଆକାଶରେ ଲାଗିଥିବା ଶବ୍ଦ ଶୁଣିବ



ଜାତୀୟତା ଓ ଶାନ୍ତିର ସମ୍ପର୍କରେ ଲେଖାଯାଇଥିବା ଏହି ପୁସ୍ତକଟି
ଆଜିର ସମସ୍ତଙ୍କ ପାଇଁ ଜାତୀୟତା ଓ ଶାନ୍ତିର ମୂଲ୍ୟକୁ ବୁଝାଇ ଦେଇଛି ଏବଂ
ଭାରତୀୟ ଶାନ୍ତିର ମୂଲ୍ୟକୁ ବୁଝାଇ ଦେଇଛି ଏବଂ ଭାରତୀୟ ଶାନ୍ତିର ମୂଲ୍ୟକୁ ବୁଝାଇ ଦେଇଛି ଏବଂ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.02.19 № 2/14

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн;
- Аймгийн ОНХС-аас эрх шилжүүлсэн 114,469.3 мянган төгрөгийн "Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн засвар"-ын ажлын худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулан засварын ажлыг гүйцэтгэсэн.
- "Дотор, мэдрэл, уламжлалтын тасаг, гал тогооны дотор засвар"-ыг Буян арвижих ХХК-тай 344,976.7 мянган төгрөгөөр гэрээ байгуулж засварыг хийлгэсэн ба тайланд онд 89,844.6 мянган төгрөгийн нэмэлт гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэсэн байна. Нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний гэрээний үнийн дүнгийн 26 тай тэнцэж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь "Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө", 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх "Нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувиас хэтрээгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол", Баянхонгор аймгийн Засаг даргын 2023.08.07-ны өдрийн А/426 дугаар захирамжийн 2 дахь хэсэгт "Эрх шилжсэнтэй холбогдуудан худалдан авах ажиллагааг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуудийн дагуу зохион байгуулж, явцын хяналт тавьж, хийгдэж дууссан ажлыг тухай бүр илтгэх хуудсаар

5020095

тайлагнаж ажиллахыг Нэгдсэн эмнэлгийн даргад үүрэг болгосугай” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 71602 (Эмнэлгийн тусламж үйлчилгээ) хөтөлбөрийн 3 арга хэмжээний зардалд 13,654,531.8 мянган төгрөгийн санхүүжилт батлагдаж, ЭМД-ийн гүйцэтгэлийн санхүүжилт 1,484,128.0 төгрөгийг дутуу авснаас авлага үүссэн ба үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 376,100.0 мянган төгрөг оруулахаас 330,275.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд эмнэлгийн үндсэн тусламж үйлчилгээг 153,406 хүний 13,252,311.4 мянга, эрт илрүүлэг 8,245 хүний 1,066,310.0 мянга, төр хариуцах эмийн зардал 168 хүний 7,206.3 мянга нийт 14,325,827.7 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс нэхэмжилсэн бөгөөд аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс хянаж үзээд 1,021,417.7 мянган төгрөгийг хасаж 13,304,409.9 мянган төгрөг олгохоос 11,829,509.4 мянган төгрөг олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 91 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 91.3 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭГТҮҮЛЭХ
АУДИТОР Д.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,243,014,483.59	3,010,758,871.02
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	352,293,035.67	4,901,305.12
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	352,293,035.67	4,901,305.12
31210	Төгрөг	352,293,035.67	4,901,305.12
31211	Төрийн сангийн харилцах	352,293,035.67	4,901,305.12
33	АВЛАГА	8,595,888.00	1,484,128,004.42
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	3,191,000.00	1,478,091,553.00
33500	Бусад авлага	5,404,888.00	6,036,451.42
33510	Байгууллагаас авах авлага	5,404,888.00	6,036,451.42
35	БАРАА МАТЕРИАЛ	1,210,195,126.92	949,864,664.48
35100	Түүхий эд материал	972,811,018.35	697,860,662.90
35110	Тусгай зориулалттай материал	130,875,048.39	167,440,780.89
35130	Эм боох материал	841,935,969.96	530,419,882.01
35400	Хангамжийн материал	237,384,108.57	252,004,001.58
35410	Бичиг хэргийн материал	2,499,120.00	2,836,400.00
35420	Аж ахуйн материал	10,537,520.20	9,673,128.20
35430	Сэлбэг хэрэгсэл	4,138,275.25	4,065,420.25
35440	Түлш, шатах тослох материал	244,650.00	0.01
35450	Барилгын засварын материал	1,803,200.00	1,668,000.00
35460	Хүнсний материал	1,344,590.00	907,300.00
35470	Бусад хангамжийн материал	216,816,753.12	232,853,753.12
36	НӨӨЦИЙН БАРАА	671,930,433.00	571,864,897.00
36100	Барааны нөөц	671,930,433.00	571,864,897.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	18,371,822,648.24	16,411,591,945.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	18,371,822,648.24	16,411,591,945.24
39200	Биет хөрөнгө	16,899,876,056.76	14,947,760,884.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,096,573,320.00	9,624,504,963.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-691,097,383.94	-814,319,443.58
39203	Авто-тээврийн хэрэгсэл	869,937,962.00	821,187,962.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-297,907,948.60	-331,555,110.04
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	12,268,317,171.90	12,301,657,979.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,757,073,094.96	-6,992,621,376.89
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	689,216,090.92	678,052,136.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	-278,090,060.56	-339,146,226.53
39300	Биет бус хөрөнгө	1,471,946,591.48	1,463,831,060.96
39301	Програм хангамж	36,007,022.00	54,707,022.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-11,885,430.52	-38,700,961.04
39303	Бусад биет бус хөрөнгө	1,447,825,000.00	1,447,825,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	20,614,837,131.83	19,422,350,816.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	1,757,062,351.22
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	1,757,062,351.22
41300	Өглөг	0	1,757,062,351.22
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	591,375,896.41
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	1,037,652,154.81
41360	Бусад өглөг	0	128,034,300.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0	26,980,400.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0	101,053,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	20,614,837,131.83	17,665,288,465.04
51	Засгийн газрын хувь оролцоо	20,614,837,131.83	17,665,288,465.04
51100	Засгийн газрын оруулсан капитал	6,725,816,344.70	6,725,816,344.70
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	6,725,816,344.70	6,725,816,344.70
51200	Хуримтлагдсан үр дүн	11,029,660,765.11	8,080,112,098.32
51210	Өмнөх үеийн үр дүн	11,367,090,599.97	11,029,660,765.11
51220	Тайлант үеийн үр дүн	-337,429,834.86	-2,949,548,666.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,859,360,022.02	2,859,360,022.02

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	20,614,837,131.83	19,422,350,816.26
----------	--	--------------------------	--------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	14,586,612,369.96	14,777,120,627.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,685,581,320.96	1,358,241,328.38
120	Нийтлэг татварын бус орлого	3,685,581,320.96	1,358,241,328.38
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	400,699,881.20	544,157,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,699,881.20	344,157,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	200,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,737,172,747.65	590,672,871.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	547,708,692.11	223,411,357.38
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,901,031,049.00	13,418,879,299.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0	114,469,329.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0	114,469,329.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,901,031,049.00	13,304,409,970.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	10,901,031,049.00	13,304,409,970.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	14,858,047,091.28	16,554,709,405.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,858,047,091.28	16,554,709,405.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,749,941,811.28	16,537,989,127.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,998,541,801.00	8,310,232,696.00
210101	Үндсэн цалин	3,729,207,166.00	4,560,378,385.00
210102	Нэмэгдэл	2,468,114,524.00	3,167,146,195.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	212,202,000.00	214,818,000.00
210104	Урамшуулал	589,018,111.00	367,890,116.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	887,289,778.39	1,053,046,658.10
210201	Тэтгэврийн даатгал	611,063,028.15	725,404,832.78
210202	Тэтгэмжийн даатгал	71,963,780.06	85,463,799.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	56,294,223.54	66,760,639.10
210204	Ажилгүйдлийн даатгал	13,436,124.33	15,943,917.21
210205	Эрүүл мэндийн даатгал	134,532,622.31	159,473,469.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,107,324,075.15	1,174,435,663.00
210301	Гэрэл, цахилгаан	129,874,776.15	136,527,727.00
210302	Түлш, халаалт	737,179,523.00	798,540,160.00
210303	Цэвэр, бохир ус	240,269,776.00	239,367,776.00
2104	Хангамж, бараа материалын зардал	429,468,263.45	272,001,316.14
210401	Бичиг хэрэг	34,824,590.00	24,882,270.00
210402	Тээвэр, шатахуун	105,636,735.89	109,241,605.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,993,373.00	12,139,837.54
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	81,258,008.00	76,941,950.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	193,755,556.56	48,795,653.00
2105	Нормативт зардал	3,067,241,483.82	3,435,874,517.93
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,679,665,013.82	3,046,145,307.93
210502	Хоол, хүнс	363,377,970.00	389,729,210.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	24,198,500.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	142,665,134.25	46,644,755.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,255,200.00	0
210604	Урсгал засвар	136,409,934.25	46,644,755.00
2107	Томилолт, зочны зардал	20,322,000.00	24,465,000.00
210702	Дотоод албан томилолт	20,322,000.00	24,465,000.00

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	287,919,063.00	234,500,815.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	265,903,095.00	213,478,652.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	3,200,000.00	3,199,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,765,988.00	1,365,788.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	333,000.00	264,000.00
210807	Газрын төлбөр	5,791,200.00	5,791,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,425,780.00	10,401,650.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,809,170,212.22	1,986,787,706.42
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,787,500.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,807,382,712.22	1,986,787,706.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	108,105,280.00	16,720,278.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	108,105,280.00	16,720,278.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	108,105,280.00	16,720,278.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-271,434,721.32	-1,777,588,778.21
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	65,995,113.54	1,171,959,888.58
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	65,995,113.54	1,162,719,238.58
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0	9,240,650.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-337,429,834.86	-2,949,548,666.79

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	14,022,171,846.20	12,491,164,730.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	404,472,616.20	547,185,984.25
120	Нийтлэг татварын бус орлого	404,472,616.20	547,185,984.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	404,472,616.20	547,185,984.25
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	404,472,616.20	347,185,984.25
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	200,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,617,699,230.00	11,943,978,746.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0	114,469,329.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0	114,469,329.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,617,699,230.00	11,829,509,417.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13,617,699,230.00	11,829,509,417.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,210,354,127.90	12,526,359,092.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,210,354,127.90	12,526,359,092.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,101,207,847.90	12,508,747,814.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,003,375,193.22	7,658,847,730.69
210101	Үндсэн цалин	3,602,603,041.00	3,447,370,325.69
210102	Нэмэгдэл	2,594,667,676.22	3,624,702,146.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	217,121,508.00	221,628,589.00
210104	Урамшуулал	588,982,968.00	365,146,670.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	887,379,252.17	1,109,926,300.00
210201	Тэтгэврийн даатгал	611,152,554.67	796,849,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	71,963,780.06	78,269,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	56,294,170.80	62,615,300.00

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	13,436,124.33	15,653,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	134,532,622.31	156,538,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,107,324,075.15	865,139,819.00
210301	Гэрэл, цахилгаан	129,874,776.15	136,527,727.00
210302	Түлш, халаалт	737,179,523.00	529,087,600.00
210303	Цэвэр, бохир ус	240,269,776.00	199,524,492.00
2104	Хангамж, бараа материалын зардал	254,331,048.00	258,078,687.54
210401	Бичиг хэрэг	11,900,070.00	11,815,200.00
210402	Тээвэр, шатахуун	102,741,300.00	111,365,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,013,373.00	12,139,837.54
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	64,808,254.00	62,564,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,868,051.00	60,193,900.00
2105	Нормативт зардал	2,689,942,258.36	2,195,994,717.57
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,287,318,598.36	1,822,261,897.57
210502	Хоол, хүнс	363,837,760.00	373,412,820.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	38,785,900.00	320,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	819,859,818.00	251,045,767.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,428,985.00	16,553,000.00
210602	Тавилга	695,000.00	0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,830,700.00	0
210604	Урсгал засвар	794,905,133.00	234,492,767.00
2107	Томилолт, зочны зардал	20,322,000.00	24,497,000.00
210702	Дотоод албан томилолт	20,322,000.00	24,497,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	316,886,703.00	145,217,793.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	270,066,095.00	114,097,280.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	3,200,000.00	3,199,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,466,188.00	1,365,788.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	623,700.00	264,000.00
210807	Газрын төлбөр	5,791,200.00	5,791,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	32,239,520.00	20,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,787,500.00	0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,787,500.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	109,146,280.00	17,611,278.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	109,146,280.00	17,611,278.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	109,146,280.00	17,611,278.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	811,817,718.30	-35,194,362.55
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	463,245,915.00	312,197,368.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	463,245,915.00	312,197,368.00
2200	Дотоод эх үүсвэрээр	463,245,915.00	312,197,368.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	463,245,915.00	312,197,368.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-463,245,915.00	-312,197,368.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	348,571,803.30	-347,391,730.55
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,721,232.37	352,293,035.67
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	352,293,035.67	4,901,305.12

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,725,816,344.70	3,050,823,344.38	11,175,627,277.61	20,952,266,966.69
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	191,463,322.36	191,463,322.36
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,725,816,344.70	3,050,823,344.38	11,367,090,599.97	21,143,730,289.05
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-191,463,322.36	0	-191,463,322.36
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-337,429,834.86	-337,429,834.86
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,725,816,344.70	2,859,360,022.02	11,029,660,765.11	20,614,837,131.83
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,725,816,344.70	2,859,360,022.02	11,029,660,765.11	20,614,837,131.83
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,725,816,344.70	2,859,360,022.02	11,029,660,765.11	20,614,837,131.83
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-2,949,548,666.79	-2,949,548,666.79
20	2023 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл	6,725,816,344.70	2,859,360,022.02	8,080,112,098.32	17,665,288,465.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,297,531,800.00	12,724,087,131.80	573,444,668.20	96%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,297,531,800.00	12,724,087,131.80	573,444,668.20	96%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,269,840,600.00	12,706,475,853.80	563,364,746.20	96%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,561,353,800.00	7,658,847,730.69	-97,493,930.69	101%
210101	Үндсэн цалин	3,825,059,100.00	3,447,370,325.69	377,688,774.31	90%
210102	Нэмэгдэл	3,116,000,000.00	3,624,702,146.00	508,702,146.00	116%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	233,259,600.00	221,628,589.00	11,631,011.00	95%
210104	Урамшуулал	387,035,100.00	365,146,670.00	21,888,430.00	94%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,109,926,300.00	1,109,926,300.00	0.00	100%
210201	Тэтгэврийн даатгал	796,849,200.00	796,849,200.00	0.00	100%
210202	Тэтгэмжийн даатгал	78,269,300.00	78,269,300.00	0.00	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	62,615,300.00	62,615,300.00	0.00	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	15,653,900.00	15,653,900.00	0.00	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	156,538,600.00	156,538,600.00	0.00	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	920,439,000.00	865,139,819.00	55,299,181.00	94%
210301	Гэрэл, цахилгаан	137,400,000.00	136,527,727.00	872,273.00	99%
210302	Түлш, халаалт	543,363,200.00	529,087,600.00	14,275,600.00	97%
210303	Цэвэр, бохир ус	239,675,800.00	199,524,492.00	40,151,308.00	83%
2104	Хангамж, бараа материалын зардал	258,142,000.00	269,813,487.54	-11,671,487.54	105%
210401	Бичиг хэрэг	11,500,000.00	11,815,200.00	-315,200.00	103%
210402	Тээвэр, шатахуун	96,000,000.00	111,365,300.00	-15,365,300.00	116%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,700,000.00	12,139,837.54	560,162.46	96%

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	67,942,000.00	62,564,450.00	5,377,550.00	92%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	70,000,000.00	71,928,700.00	-1,928,700.00	103%
2105	Нормативт зардал	2,393,000,000.00	2,195,994,717.57	197,005,282.43	92%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,011,000,000.00	1,822,261,897.57	188,738,102.43	91%
210502	Хоол, хүнс	380,000,000.00	373,412,820.00	6,587,180.00	98%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	320,000.00	1,680,000.00	16%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	782,764,600.00	418,339,006.00	364,425,594.00	53%
210601	Багаж, техник, хэрэгсэл	48,000,000.00	36,933,000.00	11,067,000.00	77%
210602	Тавилга	5,500,000.00	5,282,200.00	217,800.00	96%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,300,000.00	1,876,160.00	423,840.00	82%
210604	Урсгал засвар	726,964,600.00	374,247,646.00	352,716,954.00	51%
2107	Томилолт, зочны зардал	24,600,000.00	24,497,000.00	103,000.00	100%
210702	Дотоод албан томилолт	24,600,000.00	24,497,000.00	103,000.00	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	219,614,900.00	163,917,793.00	55,697,107.00	75%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	184,500,000.00	132,797,280.00	51,702,720.00	72%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	0	2,500,000.00	0%
210803	Даатгалын үйлчилгээ	3,200,000.00	3,199,525.00	475.00	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,500,000.00	1,365,788.00	1,134,212.00	55%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	623,700.00	264,000.00	359,700.00	42%
210807	Газрын төлбөр	5,791,200.00	5,791,200.00	0.00	100%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20,500,000.00	20,500,000.00	0.00	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,691,200.00	17,611,278.00	10,079,922.00	64%
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,691,200.00	17,611,278.00	10,079,922.00	64%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,691,200.00	17,611,278.00	10,079,922.00	64%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,297,531,800.00	12,376,695,401.25	920,836,398.75	93%
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,400,480,500.00	11,829,509,417.00	570,971,083.00	95%
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,400,480,500.00	11,829,509,417.00	570,971,083.00	95%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	897,051,300.00	547,185,984.25	349,865,315.75	61%
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	344,758,300.00	347,185,984.25	-2,427,684.25	101%
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000,000.00	200,000,000.00	0.00	100%
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	352,293,000.00	0	352,293,000.00	0%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	352,293,035.67	352,293,035.67	0%
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	4,901,305.12	-4,901,305.12	0%
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1	0.00	100%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100%

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

610001	Төсвийн байгууллага	1	0	0.00	100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	366	366	0.00	100%
620001	Удирдах ажилтан	2	2	0.00	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	264	264	0.00	100%
620003	Үйлчлэх ажилтан	100	100	0.00	100%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	366	366	0.00	100%
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	323	323	0.00	100%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	43	43	0.00	100%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг нь “Хүний нөөцийн ур чадвар, ёс зүй, манлайлал бүхий хамт олонд дулгуурлан , үйлчилгээний таатай орчинд хоёр дахь шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, ээлтэй, цогц үзүүлэх замаар хонгор нутгийн хөгжил, ард иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад оршино” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Нэгдсэн эмнэлэг нь өндөр мэргэшсэн, чадварлаг эмч, эмнэлгийн мэргэжилтнээр хүний нөөцийг бүрдүүлж, ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг дотоод гадаадын эмнэлүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн, үйл ажиллагаа нь үйлчлүүлэгч, олон нийтийн эрэлт хэрэгцээ, сэтгэл ханамжид тулгаарласан байх зарчмыг баримтлаж ажилладаг байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Нэгдсэн эмнэлгийг даргын 2018 оны 04 дүгээр сарын 27-ний А/111 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт

бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарт нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 19,422,350.8 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 1,192,486.3 мянган төгрөгөөр буюу 6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
Б	1		2		3=2-1	
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,243,014.5	11%	3,010,758.9	16%	767,744.4	34%
Мөнгөн хөрөнгө	352,293.0	2%	4,901.3	0%	-347,391.7	29%
Авлага	8,595.9	0%	1,484,128.0	8%	1,475,532.1	100%
Бараа материал	1,882,125.6	9%	1,521,729.6	8%	-360,396.0	-19%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	18,371,822.6	89%	16,411,591.9	84%	1,960,230.7	-11%
Үндсэн хөрөнгө	25,407,876.6	123%	24,927,935.1	128%	-479,941.5	-2%
Хуримтлагдсан элэгдэл	-7,036,053.9	-34%	-8,516,343.1	-44%	1,480,289.2	21%
Нийт хөрөнгө	20,614,837.1	100%	19,422,350.8	100%	1,192,486.3	-6%
Өр төлбөр	0.0		1,757,062.4	9%	1,757,062.4	100%
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	20,614,837.1	100%	17,665,288.5	91%	2,949,548.7	-14%
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	20,614,837.1	100%	19,422,350.8	100%	1,192,486.3	-6%

Эх сурвалж: Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл 1,484,128.0 мянган төгрөг болж 1,475,532.1 мянган төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 1,478,091.5 мянга, НИК ХХК-аас 5,965.2 мянга, Баянговь сумын эрүүл мэндийн төвөөс 71.2 мянга авлага нэмж үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,521,729.6 мянган төгрөг болж 360,396.0 мянган төгрөг болж буурсан нь эм боох материал үлдэгдэл 311,516.1 мянга, аж ахуйн материал 864.3 мянга, нөөцийн бараа 100,065.5 мянган төгрөгөөр тус тус буурсан нь голлох нөлөө үзүүлж байна.

Мөн тайлант хугацааны эхэнд эм боох материал 841,935.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд 2,543,077.3 мянган төгрөгийг худалдан авч ЭМЯ-аас

110,227.5 мянга, аймгийн Эрүүл мэндийн газраас 652.0 мянга, аймгийн Онцгой байдлын газраас 10,000.0 мянга, Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс 52,725.9 мянга, бусад эх үүсвэрээс 16,923.7 мянга нийт 170,838.7 мянган төгрөгийн эм боох материал худалдан авч 2,801247.4 мянган төгрөгийн эм боох материал зарцуулж 243,874.9 мянган төгрөгийн хугацаа нь дууссан эм боох материалыг акталж устгаж оны эцэст 530,419.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 24,927,935.1 мянган төгрөг болж 479,941.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 598,603.4 мянга, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 590,672.9 мянга, аймгийн ИТХ-ын шийдвэрээр акталж устгасан 459,138.6 мянга, үнэ төлбөргүй балансаас баланст 1,210,079.2 мянган төгрөгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Үндсэн хөрөнгийг данснаас хассан судалгаа /мянган төгрөгөөр/

д/д	Үндсэн хөрөнгийн нэр	Мөнгөн дүн	орлого зарлагын зүйл	Тогтоолын дугаар
1	14 ортой эмнэлгийн барилга	1,011,448.6	үнэ төлбөргүй шилжүүлсэн	Аймгийн ИТХ-ын 2023.02.13-ны өдрийн 13/04
3	Ниссан patrol Y61 93-38БНА	198,630.6	үнэ төлбөргүй шилжүүлсэн	Аймгийн ИТХ-ын 2023.12.28-ны өдрийн 137 дугаар захирамж
2	Авто тээврийн хэрэгсэл	48,750.0	Акталж данс бүртгэлээс хассан	Аймгийн ИТХ-ын 2023.02.13-ны өдрийн 13/10
4	Тавилга хэрэгсэл	29,831.2	Акталж данс бүртгэлээс хассан	Аймгийн ИТХ-ын 2023.12.05-ны 17/66
5	Машин тоног төхөөрөмж	380,557.4	Акталж данс бүртгэлээс хассан	Аймгийн ИТХ-ын 2023.12.05-ны 17/67
	Нийт дүн	1,669,217.7		

Эх сурвалж. Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангаас

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,757,062.4 мянган төгрөг болж өссөн нь эрүүл мэндийн санхүүжилт бүрэн орж ирээгүйгээс НДШ-д 269,452.6 мянга, ХАОАТ-т 371,593.4 мянга, түлш халаалтын зардалд 269,452.6 мянга, цэвэр бохир усны зардалд 39,843.3 мянга, эмийн зардалд 728,356.3, бусад зардалд 128,034.3 мянган төгрөг байгаа нь ЭМДС-аас авах авлагаар өглөгөө бүрэн барагдуулах боломжгүй байх эрсдэл үүссэн байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 17,665,288.5 мянган төгрөг болж 2,949,548.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 2,949,548.7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 16,809,106.6 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 255,340.0 мянга, нийт зарлагыг 17,064,446.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 1,702,388.2 мянган төгрөгөөр бууруулж 15,362,058.4 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 13,297,531.8 мянган төгрөг болгож 2,064,526.6 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 13,297,531.8 мянган төгрөг батлагдсанаас 12,724,087.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудит хийх хугацаанд оны эхэнд батлагдсан төсвийг ирүүлсэн бөгөөд оны эцсийн батлагдсан төсвийн хуваарийг ирүүлээгүй төсвийн гүйцэтгэлийн тайланг Э-тайлангаас авсан болно

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас харахад төсвийн нийт зардлын гүйцэтгэл 12,724,087.1 мянган төгрөгийг зарцуулж 93.2 хувьтай харагдаж байгаа ч Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт дутуу орж ирснээс хэмнэлттэй мэт харагдаж байна. *Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80801 үндсэн үйл ажиллагаа зардал	13,069,840.6	12,506,475.9	563,364.7	96%
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	27,691.2	17,611.3	10,079.9	64%
3	Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	200,000.0	200,000.0	0.00	100%
	Нийт дүн	13,297,531.8	12,724,087.2	573,444.6	96%

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс тайлант онд 1,478,091.6 мянган төгрөгийн авлагатай бөгөөд оны эцэст 1,757,062.3 мянган төгрөгийн өглөгтэй байгаа нь төсвийн нийт зардлыг 278,970.7 мянган төгрөгөөр хэтрүүлсэн харагдаж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй 2 зөрчил илэрч зөвлөмж хүргүүлээ.

1. Аймгийн ОНХС-аас 114,469.3 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэн "Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн засвар"-ын ажлыг хийж худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулан засварын ажлыг гүйцэтгэж тухайн ажлыг комисс томилон хүлээн авч барилгын сайжруулалтаар орлого авсан байна. Тус эмнэлгээс худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй талаар тодруулахад 2024.02.16-ний өдрийн 73 тоот албан бичигтээ 2023 онд мэс заслын хэвтэн эмчилгээний хэсгийн зураг төсөв гарч аймгийн ОНХС-аас 114,469.3 мянган төгрөгийг шийдвэрлүүлж Удирдах зөвлөлийн хурлын шийдвэр болон ТБОНӨХБАУХА хуулийн 34.1.4 дэх заалтын дагуу Нэгдсэн эмнэлгийн мэс заслын вакум хагалгааны хэсэг засварын ажил дээр нэмэлтээр гэрээ байгуулж засварын ажлыг хийж гүйцэтгэсэн гэсэн тайлбарыг ирүүлсэн. Тухайн нэмэлтээр гүйцэтгэсэн ажил нь мэс заслын вакум хагалгааны хэсэг засварын ажилтай ижил төстэй биш, хэвтэн эмчилгээний хэсгийн тасгийн засварын ажил байна.

Мөн Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн "Нэгдсэн эмнэлгийн мэс заслын өрөөний засварын ажлыг эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх тухай" А/426 дугаар захирамжийн 2 дэх хэсэгт "Эрх шилжсэнтэй холбогдуудан худалдан авах ажиллагааг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу зохион байгуулж, явцын хяналт тавьж, хийгдэж дууссан ажлыг тухай бүр илтгэх хуудсаар тайлагнан ажиллахыг Нэгдсэн эмнэлгийн дарга (Ч.Жавзан)-д үүрэг болгосугай.

Энэ нь Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ." гэсэн заалтыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж байх цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй зөвлөмжийг хүргүүлэв.

2. "Дотор, мэдрэл, уламжлалтын тасаг, гал тогооны дотор засвар"-ыг Буян арвижих ХХК-тай 344,976.7 мянган төгрөгөөр гэрээ байгуулж засварыг хийлгэсэн ба тайланд онд 89,844.6 мянган төгрөгийн нэмэлт гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэсэн байна. Нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний гэрээний үнийн дүнгийн 26 тай тэнцэж байна.

Энэ нь Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх "нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувиас хэтрээгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж байх зөвлөмжийг хүргүүлэв.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, ахлах аудитор М.Алтантуяа, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн 584 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2023 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Ч.Жавзан, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Сайнбаяр нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 14,858,047.1 мянган төгрөгөөс тооцоход 74,290.2 мянган төгрөг байгаа ба гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 52,003.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 оны гэрэл цахилгааны зардлыг 387.2 мянга буюу 7.8 хувь, цэвэр бохир усны зардлыг 40,151.3 мянга буюу 16.8 хувь хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

1. Иргэнээс ирсэн мэдээллийн дагуу Нэгдсэн эмнэлгийн цусны шинжилгээ авдаг газар хүнд сурталтай, иргэдийг их хүлээлгэдэг гэсэн гомдлын нийцлийн аудитын асуудалд хамруулан 2024 оны 1-сард 3 удаа, 2-р сард 1 удаа ажлын зураг авалт хийхэд иргэдэд өгөх үйлчилгээг хүндрүүлсний дараагаар нэмэлт хүн гаргаж шинжилгээ авч байгаа хариу арга хэмжээ нь нөөцийн дутагдал бус цэвэр ажлын зохион байгуулалтын алдаа гаргаж хиймэл бухимдал үүсгэдэг болох нь нотлогдож байна.

Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 21.1."Эрүүл мэндийн байгууллага дүрэмтэй байна.", аймгийн Эрүүл мэндийн даргын 2019.04.12-ны өдөр батлагдсан "Баянхонгор аймгийн Магсарын нэрэмжит Нэгдсэн эмнэлгийн дүрэм"-д тодорхойлсон зарчимтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Иймээс биохимийн шинжилгээний хэсгийн зохиомол хүнд суртал үүсгэдэг байдлыг таслан зогсоож, Эрүүл мэндийн тухай хуулийн 21.1, "Аймгийн нэгдсэн эмнэлгийн дүрэм"-г хэрэгжүүлэх талаар тодорхой үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2023 онд 159 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулахаас 159 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаcт цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12,186,555.1 мянган төгрөгийн 36 гүйлгээ цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 3,566,179.9 мянган төгрөгийн 223 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 14,329.6 мянган төгрөгийн 243 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 109,079.2 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс 2,660.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 29,513.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 76,904.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023.05.19-ны өдрийн 333 дүгээр албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	2,660.5	2	2,660.5	100
Албан шаардлага	1	29,513.8	1	29,513.8	100
Зөвлөмж	3	76,904.9	3	76,904.9	100
Нийт дүн	6	109,079.2	6	109,079.2	100

Эх сурвалж: 2023 оны аудитын тайлангаас

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын мэргэжилтэн Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны 1 сарын өдрийн эмчилгээний тусламж үйлчилгээний байдалд хяналт шалгалт хийхэд нэр бүхий 71 ажилтны хувийн мэдээлэл регистрийн дугаарыг ашиглаж өдрийн эмчилгээний түүхийг хуурамчаар үйлдэн эрүүл мэндийн даатгалын сангаас 18.7 сая төгрөгийг нэхэмжилсэн нь газар дээрээ нотлогдсон гэсэн мэдээллийг хийсэн.

Үүний дагуу аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс 2023 оны өдрийн эмчилгээний дата файлыг татан авч цахим программыг ашиглан Нэгдсэн эмнэлгийн ажилтнуудын регистрийн дугаартай тулгалт хийхэд тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 332 буюу 183 ажилтан (нийт ажиллагсдын 55 хувь) өдрийн эмчилгээнд хамрагдсан.

Иймд дараагийн аудитаар эрүүл мэндийн байгууллагуудын ЭМД-аас авч байгаа санхүүжилтэд шалгалт хийхдээ аудитын хамрах хүрээг тэлж шалгах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 380.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 380 мянган төгрөгийн 1 алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

5.1 Зөвлөмж

1.Нэгдсэн эмнэлгийн даргын 2023.04.13-д Б/114 дүгээр тушаалаар төрийн дээд одон медалиар шагнуулсан шагналын зардалд 180.0 мянга, мөн 2023.10.16-ний өдөр Б/334 дүгээр тушаалаар нэг удаагийн тэтгэмжид 200.0 мянган төгрөгийг тус тус Нэгдсэн эмнэлгийн дарга өөртөө тушаал гарган зарцуулсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын төсөв захирагчтай холбоотой хөрөнгө зарцуулах шийдвэрийг ТУЗ-өөр шийдвэрлүүлж байх зөвлөмжийг хүргүүлж байна.

Дээрх Зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор, хэрэгжилтийн нотлох баримтын хамт 2024 оны 05 дугаар сарын 30 ны өдрийн дотор цаасаар болон FAS системээр ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэгдсэн эмнэлгийн даргын 2023.04.13-д Б/114 дүгээр тушаалаар төрийн дээд одон медалиар шагнуулсан шагналын зардалд 180.0 мянга, мөн 2023.10.16-ний өдөр Б/334 дүгээр тушаалаар нэг удаагийн тэтгэмжид 200.0 мянган төгрөгийг тус тус өөртөө тушаал гарган зарцуулсан байна.	1	380.0	-	-	-	-	1	380.0
Дүн	1	380.0					1	380.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Аймгийн Засаг даргын 2023.08.07-ны өдрийн А/426 дугаар захирамжаар "Нэгдсэн эмнэлгийн мэс заслын өрөөний засварын ажлыг эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх тухай захирамжийн дагуу аймгийн ОНХС-аас 114,469.3 мянган төгрөг тухайн байгууллагад эрх шилжиж ирсэн бөгөөд тус захирамжийн 2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй шууд худалдан авалт хийсэн байна.	1	114,469.3			1	114,469.3
"Дотор, мэдрэл, уламжлалтын тасаг, гал тогооны дотор засвар"-ыг Буян арвижих ХХК-тай 344,976,737 төгрөгөөр гэрээ байгуулж засварыг хийлгэсэн ба тайланд онд 89,844,574 төгрөгийн ажлыг тендер зарлалгүйгээр нэмэлт гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэсэн байна.	1	89,844.6			1	89,844.6
Иргэнээс ирсэн мэдээллийн дагуу шалгахад Нэгдсэн эмнэлгийн лабораторийн иргэдэд учруулж байгаа чирэгдэл нь Эрүүл мэндийн тухай хуулийн 21.1, "Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дүрэм"-г хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.	1	0			1	0
Дүн	3	204,313.9			3	204,313.9

-----oOo-----